



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/39

Улаан-Уул

Мал, амьтны халдварт өвчнөөс  
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/177 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл технологит хугацаанд хийж гүйцэтгэхийг “ДЭНЗӨ” ХХК малын их эмч С.Даваа, “Түйн дэлгэрэх” хоршооны малын их эмч А.Мягмар, “Эх тал газар” ХХК-ны малын их эмч Г.Баасансүрэн, “Түмэн сүргийн хишиг” ХХК-ны малын их эмч Г.Ганбат нарт тус тус даалгасугай.

2. Мал эмнэлгийн дуудлага, цаг үеийн яаралтай дархлаажуулалтын ажилд Бурхант 1 дүгээр баг, Улаан уул 6 дугаар багийг малын их эмч (А.Мягмар), Ёлын ам 3 дугаар багийг малын их эмч (С.Даваа), Байн ам 2 дугаар, Худаг урт 4 дүгээр багийг малын их эмч (Г.Ганбат), Бийрийн уулзвар 5 дугаар багийг малын их эмч (Г.Баасансүрэн) нар тус тус хариуцан ажиллахыг даалгасугай.

3. Дархлаажуулалтад мал сүргээ тогтоосон хугацаанд бэлэн байлгаж бүрэн хамруулах, дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн дотор тухайн малчны хотноос мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд борлуулах, нөөц бүрдүүлэхгүй байхыг малчид, иргэд, аж ахуйн нэгжүүдэд анхааруулсугай.

4. Дархлаажуулалтын ажлын төлөвлөгөөг мал эмнэлгийн нэгдсэн системд тархвар зүйн зураглалын дагуу оруулах, технологийн дагуу чанартай хийж

**642201051**

гүйцэтгэхэд хяналт тавих, гүйцэтгэлийг баталгаажуулж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (О.Намжирмаа)-д, дархлаажуулалтын товыг зарлан мэдээлж өрх бүрт хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДӨНЭБАТ

